

# БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

## ИЛТГЭХ ХУУДАС

2023 оны 02 дугаар сарын 28

Номгон

Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл,  
арга хэмжээний хэрэгжилтэд хяналт шинжилгээ,  
үнэлгээ хийсэн тухай

Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний 2022 оны хэрэгжилтэд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагад хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” -ын дагуу хяналт шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн хүрээнд сум, агентлагуудын үйл ажиллагааны тайлан, шалгуур үзүүлэлтийн дагуу тоон мэдээлэлд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсгийг 4 чиглэлд “Сумдын Засаг даргын Тамгын газар, төсөвт байгууллагуудын 2022 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх тухай” удирдамжийн дагуу сумдад ажиллан “Тэрбум мод”, “Хог хаягдлын менежментийг сайжруулах” “Цахим шилжилт”-ийн чиглэлээр хийсэн ажлын тайланг бодит байдал дээр нь тулган баталгаажуулж үнэлэлт дүгнэлт өгч ажилласан.

“Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг үнэлж, зөвлөмж боловсруулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А/78 дугаар захирамжаар байгуулж, ажлын хэсэгт мэргэжлийн хүмүүсийг татан оролцууллаа.

“Тэрбум мод” “Хог хаягдал”, “Цахим шилжилт” зэрэг тэргүүлэх чиглэлийн тайлан нь төрийн байгууллагууд, хэлтэс, агентлаг, сум орон нутагт хийгдсэн ажлыг нэгтгэн тайлагнаснаараа үр дүнтэй, онцлог байсан.

### **1.Хяналт шинжилгээ, үнэлгээний үр дүн:**

2022 онд 500,000 ширхэг модыг тарьж ургалтын хувийг 70%-д хүргэх зорилт тавьсан бөгөөд 522,808 ширхэг мод, бут, сөөгийг тарьж ургалтын хувь 70,64%-д хүрсэн байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 131 дүгээр тогтоолоор “Хог хаягдлын менежментийг сайжруулах аймгийн хөтөлбөр”-ийг хэлэлцэн батласан. Тус хөтөлбөр нь 4 бүлэг 26 зорилтоос бүрдэх бөгөөд тус онд хөтөлбөрийн хэрэгжилтийг 70,64 хувьтай хэрэгжүүлж ажилласан байна.

2022 онд Баянхонгор аймаг цахим засаглал, цахим шилжилтэд төр-хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан “ДИЖИТАЛ БАЯНХОНГОР” болох томоохон зорилтыг дэвшүүлэн ажилласан ба хэрэгжилтийг 90 хувьтай хэрэгжүүлж ажилласан байна.

Хяналт шинжилгээ, үнэлгээгээр Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний 2022 оны хэрэгжилтийг “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэв.

#### **Нэг.Ногоон байгууламж: (Мод тарих)**

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг идэвхижүүлэх, мод тарих шинэ арга, технологийг нэвтрүүлэх, иргэд аж ахуйн нэгжийн төлөөллийн санал санаачилгыг хэлэлцүүлж, цаашид хэрэгжүүлэх бодлогыг танилцуулах зорилгоор аймгийн Засаг даргын 2022 оны А/101 дугаар захирамжийн дагуу аймгийн “Ойн салбарын анхдугаар чуулган”-ыг 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдөр зохион байгууллаа. Байгаль орчны салбарын байгууллагууд, сум, орон нутгийн удирдлага, мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй нөхөрлөл, бүлэг иргэдийн төлөөлөл бүхий нийт 300 гаруй хүн оролцсон байна.

Чуулганаар Баянхонгор аймгийн 2030 он хүртэлх 20,0 сая мод тарих стратеги төлөвлөгөөг хэлэлцэж, иргэн, аж ахуйн нэгжийн төлөөлөл мод тарих амлалт, батламжийг аймгийн Засаг даргад гардуулсан. Мөн аймгийн Засаг дарга сумдын Засаг дарга нартай 2030 он хүртэл 1,0 сая модыг тарьж ургуулан, арчилгаа, хамгаалалтыг хариуцах хариуцлагын гэрээ байгуулсан байна.

Аймгийн хэмжээнд нийт 6414 иргэн, 537 аж ахуйн нэгж байгууллага 892,346,600 төгрөг зарцуулж, 522,808 ширхэг мод тарьсан. Нийт тарьсан модны амьдралтын хувь 70,54% байна. Үүнд:

- 1595 айл өрх 18627 ширхэг мод
- Бичил цэцэрлэг саад хүрээлэнд 74862 ширхэг мод
- 57,8 га талбайд Нэрэмжит ой төгөл шинээр байгуулан 12868 ширхэг мод
- 10,2 га талбайд шинээр 10 бичил цэцэрлэг байгуулан 11695 ширхэг мод,
- 71,9 га талбайг зүлэгжүүлэн
- 27,4 га талбайд 10 ширхэг цэцгийн мандал
- Төв суурин газрын 34,7 га талбайд 18768 ширхэг мод,
- Хамгаалалтын ойн зурваст 106,5 га талбайд 36924 ширхэг мод,
- Хээрийн ойжуулалтад 121,7 га талбайд 38064 ширхэг мод
- Мод үржүүлгийн газарт 311,000 ширхэг суулгацыг тус тус тарьж усалгаа арчилгааг технологийн дагуу хийсэн байна.

Орон нутгийн хөрсөнд дасан зохицсон тарьц суулгацаар хангах зорилгоор бүсчилсэн Мод үржүүлгийн газруудыг байгуулав. Үүнд:

- Мод үржүүлгийн газрын талбайг 2021 онд 10 га хүртэл нэмэгдүүлсэн бол тус онд 10 га талбайн хашааг бүрэн шинэчилж, иж бүрэн усалгааны систем суурилуулж, ногоон

байгууламжийн усалгаанд шаардлагатай 2 худгийг гарган, 6\*20 хэмжээтэй 10 ширхэг зуны хүлэмж, зоорь, 8\*6 хэмжээтэй мод тарьц, суулгац худалдаалах байрыг барьсан.

- Мод үржүүлгийн газрын тарьц суулгацын нөөцийг нэмэгдүүлэхээр 3 төрлийн 55,000 ширхэг (Сухай, Улиас, Бургас) мөчрийн тайраадас, эх ургамлын нөөц бэлтгэх зорилгоор 10 төрлийн 2000 ширхэг тарьц, суулгац, 12 төрлийн 606 кг (бохир жингээр) үрийн нөөцөөр хангагдсан. Энэ онд 115,000 ширхэг улиас, 123,000 ширхэг бургас, 12,000 ширхэг сухай нийт 3 төрлийн 250,000 ширхэг мөчрийн тайраадасыг талбайд, 4 төрлийн 26 кг үрийг хүлэмжинд тус тус тариалсан.

- Мөн ногоон байгууламжийн арчилгаанд шаардлагатай 12 нэр төрлийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг худалдан авсан байна.

- Сум дундын ойн анги нь өмнөх онуудад жилд 5-10 мянган ширхэг тарьц суулгац нийлүүлдэг байсан бол ирэх онуудад жилдээ 250-500 мянган ширхэг тарьц суулгац нийлүүлэх боломжийг бүрдүүлжээ.

- Шинэ суурьшлын бүсийн 2 га талбайд 600 м хашаа, 8\*10 хэмжээтэй оффисын байшин, усалгааны систем бүхий аймгийн төв болон төвийн бүсийг тарьц суулгацаар хангах шинэ мод үржүүлгийн газрыг байгуулсан. Тус мод үржүүлгийн газарт энэ онд хайлаасны 10 кг үр, 5 төрлийн 1600 ширхэг эх мод, 50,000 ш бургас, улиас, уд модны тайраадас суулгасан.

- Говийн бүсийн сумдыг тарьц суулгацаар хангах зорилгоор 2008 онд байгуулагдсан Богд сумын Мод үржүүлгийн газарт 8\*30 хэмжээтэй автоматжуулсан хүлэмж, иж бүрэн усалгааны систем, 12 тн багтаамжтай ус хуримтлуулах савыг тус тус байршуулсан.

- Эрдэнэцогт сум Мод үржүүлгийн газар шинээр байгуулж 10,000 ширхэг тайраадасыг тариалав.

- Хөдөлмөр, халамж үйлчилгээний газраас “Ногоон ажлын байр” хөтөлбөрийн хүрээнд Баянхонгор суманд модны нүх ухах, хөрс бэлтгэх, хайс хамгаалалт засаж янзлах, мод тарих, арчилгаа усалгаа хийх, зүлэг цэцгийн мандал тариалах зэрэг ажлуудад 997 иргэнийг хамруулж, түр ажлын байраар ханган нийт 244,2 сая төгрөгийн урамшууллыг олгосон.

- Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Ойн бодлого зохицуулалтын газар, Монгол Улсын Их Сургууль, “Монголын унаган байгалийн хүлцэл тогтворжилтыг хангах нь төсөл”-ийн багтай Байгаль орчин, аялал жуулчлалын газар хамтран “Мод тарих 1000 сургагч багш”-ийн хээрийн сургалтын хүрээнд 2022 оны 07 дугаар сарын 24-26-ны өдрүүдэд зохион байгуулж 20 сумын 60 иргэнийг хамруулсан.

#### **Дүгнэлт:**

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, Монгол Улсын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан

Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээнд тусгагдсан Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Баянхонгор аймаг нийт 3 Мод үржүүлгийн газрыг шинээр байгуулж, 1 мод үржүүлгийн газрын үйл ажиллагааг өргөтгөж, улмаар нутгийн хөрсөнд зохицсон 250,0-500,0 мянган тарьц суулгацыг жилд нийлүүлэх боломжийг бүрдүүлжээ.

2.Тайлант онд нийт 522,808 ширхэг модыг шинээр тарьснаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10 дахин их мод тарьж, түүний усалгаа, арчилгаанд хүн хүч, хөрөнгө санхүүг зарцуулан амьдралтын хувийг 70,54 хувьд хүргэсэн байна.

3.Аймгийн хэмжээнд нийт газар нутгийн 0,3 хувь буюу 36309,92 га талбайг Хот, тосгон бусад суурин газар эзэлдэг. Урьд онуудын судалгаагаар хот тосгон бусад суурин газрын 0,14 хувь буюу 52,6 га талбайг ногоон байгууламж эзэлдэг байсан бол энэ онд төв суурин газрын 34,7 га талбайд 18768 ширхэг мод, 57,8 га талбайд Нэрэмжит ой төгөл шинээр байгуулан 12868 ширхэг мод, 10,2 га талбайд шинээр 10 бичил цэцэрлэг байгуулан 11695 ширхэг модыг тус тус тарьсанаар хот суурины эдэлбэр газарт ногоон байгууламжийн хэмжээг 102,7 га талбайгаар буюу 2 дахин нэмэгдүүлсэн нь хот суурины эдэлбэр газарт ногоон байгууламжийн эзлэх хувийг 0,42 хувь болгон нэмэгдүүлсэн байна.

#### **Санал (зөвлөмж):**

1.Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд улсын ойжуулалтын нэгдсэн бодлого гаргаж, түүнээс улбаалан орон нутагт хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай байна.

2.Сумдууд ойн нөхөрлөл, хамтлаг байгуулж хайс хамгаалалт, усалгаа арчилгаа, тарьц суулгацаар хангах, иргэдийг байнгын ажлын байраар хангаж, жимс, жимсгэнэ, хүнсний ногоо бүхий агро парк хэлбэрээр зохион байгуулбал энэ ажлын үр дүн сайнаар гарахад нөлөөлнө.

3.Сумдад тарьсан мод суулгацын хайс, хамгаалалт, усалгааны арчилгаа, цалин хөлсний асуудлыг иж бүрэн шийдэхгүйгээр төрийн албан хаагчдад хавсрага болгон хариуцуулсан нь энэ ажлын эцсийн үр дүнд сөргөөр нөлөөлж болзошгүй байна.

#### **Хоёр.Хог хаягдлын менежмент:**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 131 дүгээр тогтоолоор "Хог хаягдлын менежментийг сайжруулах аймгийн хөтөлбөр"-ийг хэлэлцэн батласан. Тус хөтөлбөр нь 4 бүлэг 26 зорилтоос бүрдэх бөгөөд тус онд хөтөлбөрийн хэрэгжилтийг 70,64 хувьтай хэрэгжүүлж ажилласан байна.

Хог хаягдлын менежментийг сайжруулах ажлын хүрээнд:

- Бүх нийтийн цэвэрлэгээ, хур хог хаягдлыг цэвэрлэх ажлыг тогтмолжуулж давхардсан тоогоор ерөнхий боловсролын сургуулийн 6469 сурагч, 6415 иргэн

оролцож нийт 2446 удаагийн рейсээр 31685 тонн хог хаягдлыг цэвэрлэж, хог хаягдлын төвлөрсөн цэгт хүргэсэн байна.

- "Усны сан бүхий газрыг бохирдож, хомстохоос хамгаалах" зорилгоор усны сан бүхий газар, түүний хамгаалалтын бүс орчмын хог хаягдлыг цэвэрлэх аяныг зохион байгуулж, нийт 20 сумын 27 усны сан бүхий газрын 988,85 га талбайн 111,6 тонн хог хаягдлыг цэвэрлэсэн бөгөөд тус үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэний төлөөлөл 3135 хүн оролцож, 32 машин техникээр зөөвөрлөн төвлөрсөн хогийн цэгт хүргэсэн.

- Нийт 12 сумын хог хаягдлын төвлөрсөн цэгийг цэгцлэж, сайжруулснаас Баянхонгор сум Орон нутгийн хөгжлийн сангийн 200,0 сая төгрөгний санхүүжилтээр 70 метр өргөнтэй, 100 метр урттай, 4 метрийн гүн, 4 метрийн өндөр далан бүхий нийт 8 метрийн гүнтэйгээр стандартын шаардлагад нийцүүлсэн, Баянцагаан сум Орон нутгийн хөгжлийн сангийн 20,0 сая төгрөгийн санхүүжилтээр хогийн цэгийн талбайгаа цэгцэлж хашаажуулсан, Гурванбулаг сум хуучин хогийн цэгээ дарж, хашаа, хамгаалалт бүхий шинэ хогийн цэг байгуулж, камержуулсан, Богд сум 25 га талбай бүхий олон жилийн хур хог хаягдлын цэгийн талбайг цэгцэлж, багасгасан, Баянговь сум 42 га талбай бүхий олон жилийн хур хог хаягдлын цэгийн талбайг цэгцэлж, карьерлан 1 га болгон хашаалсан, шатаах зуух байршуулсан, түрж булах квоштой болсон, Баянлиг сум 12 га газрыг далан үүсгэн булжилж цэгцлэн 04 кв-ын өргөтгөл шугам татаж 360 градуст эргэдэг камер суурьлуулж, квоштой болсон, Бууцагаан, Баянбулаг, Жаргалант сум хогийн цэгийн талбайг тэлэлтээс хамгаалж хайсжуулан тэмдэг тэмдэглэгээ байршуулсан, Галуут суманд уул уурхайн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүд тус сумын хогийн цэгийн нийт 1,77 га талбайгаас 0,9 га талбайг түрж, цэгцэлсэн, Хүрээмарал сум Орон нутгийн хөгжлийн сангийн 98,3 сая төгрөгийн санхүүжилтээр "Жи-Эс -Би-Юу" ХХК-тай гэрээ байгуулан хуучин хогийн цэгийг Ландшафтийн аргаар дарж булшлан шинэ хогийн цэгийг байгуулсан зэрэг ололттой ажлууд хийгдсэн байна.

- Хог хаягдлын талаарх хууль тогтоомжийг сурталчлах сургалт сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээг аймгийн хэмжээнд 87 удаа зохион байгуулж нийт 258 төрийн албан хаагчид, 812 иргэд, ерөнхий боловсролын сургуулийн 2064 сурагчид сургалтад хамрагдаж, Баянбулаг, Заг сум 400 ширхэг гарын авлага бэлтгэн иргэдэд тараан мэргэжил арга зүйгээр ханган ажилласан байна.

- Иргэдийн хог хаягдлыг ангилан ялгах ажилд уриалах зорилгоор Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газар дахивар хог хаягдлыг түүж, тушаадаг 4 иргэнд 400,000 төгрөгийн урамшуулал олгосон. Мөн засмал зам дагуух хайрга чулуу түүх, нийтийн эзэмшлийн талбайн хог хаягдал, чулуу түүх ажилд давхардсан тоогоор 121 иргэнийг түр ажлын байраар ханган 30,2 сая төгрөгийн урамшуулал олгосон.

- Заг сум иргэдийнхээ дунд “Байгальд ээлтэй өрх” болзолт уралдааныг зарлаж шалгарсан өрхөд 1,0 сая төгрөгийн урамшуулал олгосон.

- Баян-овоо сум Ерөнхий боловсролын сурагчдын дунд тамхины иш цэвэрлэх аян зарлаж, 1 кг тамхины ишийг 20,0 мянган төгрөгөөр худалдан авсаны үр дүнд 13 кг тамхины иш цугларсан байна.

- Бөмбөгөр сум Орон тооны бус иргэдийн бүлгийг 6 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан нийтийн эзэмшлийн гудамж талбайн хог хаягдлыг тогтмол цэвэрлүүлэн ажиллаж байна.

Тус аймагт хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, дахин ашиглах үйл ажиллагааг 2021 оноос эрчимжүүлж, иргэдэд сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулж ирсэн. Аймгийн хог хаягдлын менежментийн гол зорилго нь хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж, дахин ашиглах, хоёрдогч түүхий эдийг цуглуулж эдийн засгийн эргэлтэд оруулах юм.

- Тайлант онд иргэдийг хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор аймгийн төв буюу Баянхонгор суманд 3 төрлөөр ангилан ялгах боломжтой хогийн савыг нийтийн орон сууцнуудад 24ш, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг 21ш, шатахуун түгээх станц 20ш, худалдаа үйлчилгээний газар 50ш, 2 төрлөөр ангилан ялгах боломжтой хогийн сав төв зам дагуу 51ш, хуванцар сав хийх зориулалттай хогийн савыг багийн спорт заалнуудад 6ш, нийт 166 ширхэг стандартын ангилан ялгах хогийн савыг байршуулсан.

- Жинст сум Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага үүсэж хөгжсөний 30 жилийн ойг угтан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас “Уралдья” аян зарлаж, “Таван элс” 3 дугаар багийн 1 дүгээр гудамжыг жишиг гудамж болгон 12 айлд стандартын шаардлага хангасан Эко ОО, хашааны гаднаас хогийг ачих ангилан ялгах хогийн савыг байршуулсан.

- Баянхонгор суманд “Хонгор дуулим” ХХК, “Талст болор” ХХК, Галуут суманд “Хонгор дуулим” ХХК-ний Галуут сумын нутгийн буян салбар хоёрдогч түүхий эдийг худалдан авч, эдийн засгийн эргэлтэд оруулж байна. Энэ онд аймгийн хэмжээнд 1080,54тн хогийг дахин ашиглах, боловсруулалтад нийлүүлж эдийн засгийн эргэлтэд оруулсан байна.

- Баянцагаан сумын 1 дүгээр багийн иргэн Б.Гансүх нь 2022 оны 10 дугаар сараас сумандаа хоёрдогч түүхий эдийг худалдан авч Улаанбаатар хот руу тээвэрлэн борлуулж эхэлсэн. Баянлиг сумын иргэн Цэндцэвээн нь баглаа боодол болон гялгар уутыг худалдан авч мөн Улаанбаатар хот руу тээвэрлэн “Эвт ундарга” ХХК-д нийлүүлж байна. Мөн Жинст сумын иргэн Энхтүвшин, Гантөмөр нар тус сумын уурын зуухнаас

гарч буй 90 тн үнсээр 9,0 мянган ширхэг блок үйлдвэрлэн зах зээлд нийлүүлсэн зэрэг санал санаачилгууд гарч байгаа нь сайшаалтай.

#### **Дүгнэлт:**

1.Тайлант онд аймгийн 20 сумаас 14 сум нь орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт болон орон нутгийн төсөв, хандив дэмжлэгийн хүрээнд хог хаягдлын төвлөрсөн цэгийг сайжруулан тохижуулсан.

2.Сумдын Засаг даргын Тамгын газраас тэмдэглэлт өдөр, баяр наадам зэргийг тохиолдуулан бүх нийтийн цэвэрлэгээг тогтмол зохион байгуулж хэвшсэн төдийгүй ил задгай хог хаягдал, хур хог хаягдалгүй болсон байна.

3.Хог хаягдлын талаарх хууль тогтоомжийг сурталчлах сургалт сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээг аймгийн хэмжээнд 87 удаа зохион байгуулж нийт 258 төрийн албан хаагчид, 812 иргэд, ерөнхий боловсролын сургуулийн 2064 сурагчид сургалтад хамруулж, иргэдэд хог хаягдлын талаарх ойлголт, мэдлэгийг олгосон.

4.Баянхонгор суманд “Хонгор дуулим” ХХК, “Талст болор” ХХК хоёрдогч түүхий эдийг цуглуулан ажлын байрыг бий болгож эдийн засгийн эргэлтэд оруулж байна.

Хөдөө орон нутгаас Баянцагаан сумын иргэн Гансүх, Баянлиг сумын иргэн Цэндцэвээн, Галуут сумын иргэн Ж.Алтанцэцэг, Жинст сумын иргэн Энхтүвшин, Гантөмөр нар өөрсдийн бизнесийн үйл ажиллагаанд тулгуурлан хог хаягдлыг дахин ашиглах, цуглуулах үйл ажиллагааг хийж эхэлж байгаа нь сайшаалтай.

Аймгийн хэмжээнд мод тарих, хог хаягдлыг бууруулах үйл ажиллагаанд давхардсан тоогоор 1118 иргэнийг түр ажлын байраар хангаж 274,4 сая төгрөгийн цалин урамшуулал олгосон.

#### **Санал (зөвлөмж):**

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 131 дүгээр тогтоолоор "Хог хаягдлын менежментийг сайжруулах аймгийн хөтөлбөр"-ийг эрчимжүүлэн ажиллах шаардлагатай.

2.Баянхонгор сумын Засаг дарга шийдвэр гарган ангилан ялгаагүй хог хаягдлыг ачихгүй шийдвэр гаргаж, 2023 оны 1-р сараас мөрдөн ажиллаж байгааг бусад сумууд хэрэгжүүлж ажиллах;

#### **Гурав. Цахим шилжилт, Цахим засаглал**

Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт "Цахим Монгол" төрийн шуурхай үйлчилгээ, "Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилт 5.3-д "Хүний хөгжлийг дэмжсэн, үр дүн, үр нөлөөтэй цахим засаглалыг төлөвшүүлнэ.", "Шинэ сэргэлтийн бодлого", "Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого 2025"-ийн 2.3.8-д "Төрийн байгууллагын үйл ажиллагааны бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх, засаглалыг

ардчилсан, нээлттэй, хүнд сурталгүй, ил тод, хариуцлагатай байдлыг идэвхжүүлэх, төрийн үйл ажиллагааны инновацыг дэмжиж, цахим засгийн хөгжлийг боловсронгуй болгох замаар цахим засаглалыг хөгжүүлнэ” гэж тус тус заасныг үндэслэн 2022 онд Баянхонгор аймаг цахим засаглал, цахим шилжилтэд төр-хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан **“ДИЖИТАЛ БАЯНХОНГОР”** болох томоохон зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

Тус зорилтын хүрээнд аймгийн 2022 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд 7 ажил, арга хэмжээг төлөвлөн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж, холбогдох санхүүжилтийг төсөвт суулган хэрэгжүүлжээ. Энэ ажлын хүрээнд:

- E-Mongolia системийн ашиглалтыг сайжруулах, иргэдэд таниулах, хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор удирдлага арга зүйгээр хангаж ажилласан байна.
- Төрийн цахим шилжилтийн үр дүнг таниулах, тоон бичиг үсгийн чадварыг дээшлүүлэх “Inspaire 2022 цахим шилжилтийг хүн бүрд” төслийг хэрэгжүүлж байна.
- “Баянхонгор аймгийн цахим мэдээллийн нэгдсэн систем”-ийн нэмэлт хөгжүүлэлтийг доорхи хүрээнд хийсэн байна.
  - Аймгийн албан ёсны цахим хуудасны нэмэлт хөгжүүлэлт
  - Сумдын хуудасны нэмэлт хөгжүүлэлт
  - Иргэдийн санал гомдол илгээх систем
- Байгууллагын дотоод удирдлагын нэгдсэн систем ашиглалтыг Төрийн бүх шатны байгууллагуудад хэрэгжүүлэн ажиллаж байна.

• Баянхонгор аймгийн төрийн 27 үйлчилгээ “E mongolia” системд нэвтэрч байсан бол цахим жишиг аймаг болох зорилтын хүрээнд төрийн байгууллагуудын үйлчилгээнд цахим шилжилтүүд үргэлжлэн хийгдэж, хөгжүүлэлт явагдсанаар 31 үйлчилгээг e-mongolia.mn цахим системд нэвтрүүлж ажиллажээ.

• Төрийн үйлчилгээний нэгдсэн төв нь 2019 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн операторын хэлбэрээр үйлчилгээ үзүүлдэг “Үйлчилгээний нэгдсэн төв” болж өөрчлөн зохион байгуулагдан 5 төрийн байгууллагын 198 төрлийн үйлчилгээг иргэдэд хүргэж байна. Өдөрт дунджаар 100-150 иргэнийг давхардсан тоогоор хүлээн авч үйлчилдэг.

• Тайлант онд төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал E-Mongolia системд иргэн, аж ахуйн нэгж, гадаадын иргэнтэй холбоотой 1588 төрлийн үйлчилгээ нэвтэрч,



6800 иргэнд бүртгэл үүсгэж, 18 иргэний гадаад паспортын сунгалт, 27 иргэний жолооны үнэмлэхийн хугацааг сунгаж шинээр захиалсан, 24 иргэнд цахим үнэмлэх захиалсан, операторын ажлын хүрээнд иргэдэд хүргэж буй 244 төрлийн үйлчилгээнээс 2022 оны байдлаар нийт 4367 иргэнд лавлагаа мэдээлэл гаргаж, цахим үйлчилгээг 11167 иргэнд хүргэж, M-SIGN байгууллагын цахим тоон гарын үсгийг 28 аж ахуйн нэгж байгууллагад олгоод байна.

- Эрүүл мэндийн салбарын “Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл сунгах” үйлчилгээнд 16 хүсэлт ирснээс шийдвэрлэсэн 10, татгалзсан 2, Онцгой байдлын газрын “Ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт гаргах” үйлчилгээнд 14 хүсэлт ирснээс шийдвэрлэсэн 14, Цагдаагийн газар “Хяналтын камерын тодорхойлолт гаргах” үйлчилгээнд 25 хүсэлт ирснээс шийдвэрлэгдсэн 20, татгалзсан 5 үйлчилгээ нийтдээ аймгийн хэмжээнд 55 үйлчилгээг цахимаар үзүүлжээ.

- Үйлчилгээний нэгдсэн төвд 5 байгууллагын 8 мэргэжилтэн 198 төрлийн төрийн үйлчилгээг иргэдэд тасралтгүй үзүүлж, хөдөлмөр халамжийн үйлчилгээг 11476 иргэнд, Улсын бүртгэлийн үйлчилгээг 2596 иргэнд, газрын үйлчилгээг 6287 иргэнд, Хууль зүйн туслалцааны төв нь өмгөөлөл хүлээн авсан хэрэг 46, хэргийн холбогдогч 49, зөвлөгөө 213, эрүүгийн чиглэлээр 112, иргэний чиглэлээр 82, захиргааны чиглэлээр 8, нийт 510 иргэнд, Нотариатын үйлчилгээ Гэрээ- 2712, Итгэмжлэл-1036, Гарын үсгийн баталгаа-288, Өвлөх эрхийн гэрчилгээ-126, Хуулбар үнэн-1610 нийт 4162 хүнд үйлчилгээ үзүүлсэн байна.

- Аймгийн хэмжээнд Төрийн үйлчилгээний нэгдсэн 1 төв, 20 сумын үйлчилгээний төвөөс жилийн эцсийн байдлаар төрийн үйлчилгээг нийт 51787 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад түргэн шуурхай, нээлттэй үйлчилгээ үзүүлэн ажилласан байна.

- Мөн "Иргэдийн санал гомдол илгээх систем"-ийн хөгжүүлэлтийн ажлыг "Анар системс" ХХК-тай 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 2022/158 дугаартай гэрээ байгуулан гүйцэтгүүлж 2022 оны 11 дүгээр 28-ны өдөр бүрэн хүлээн авсан. Тус системээр дамжуулан төрийн байгууллагын үйл ажиллагаанд иргэдийн сэтгэл ханамжийн судалгаа авах, иргэдээс өргөдөл, санал гомдол хүлээж авах, шийдвэрлэх явцыг тухайн мэдээлэл оруулсан иргэний гар утсанд шууд мэдээлэх зэрэг цахим технологийн тусламжтай иргэд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд шууд хяналт тавих боломжтой болжээ.

- Баянхонгор аймаг нь 2012 оноос хойш байгууллагын дотоод удирдлагын нэгдсэн системийг аймгийн хэмжээний бүх төсвийн байгууллагад нэвтрүүлэн албан бичиг солилцоо, төрийн байгууллага хооронд мэдээлэл дамжуулах үйл ажиллагааг бүрэн цахимаар шийдвэрлэж ирсэн бөгөөд 2022 оны 01 сарын 01-ээс эхлэн өмнө ашиглаж байсан байгууллагын дотоод удирдлагын “Эйбл” системээс татгалзаж шинээр И-Монгол академиас хөгжүүлэлт хийгдэж буй [erp.e-mongolia.mn](http://erp.e-mongolia.mn) системд төсвийн болон

орон нутгийн өмчит бүх байгууллагыг бүрэн шилжүүлж, Аймгийн хэмжээнд нийт 190 байгууллагын 3323 төрийн албан хаагч бүртгэгдэж албан бичиг, дотоод удирдлагын хяналт, мэдээлэл солилцооны нэгдсэн системээр дамжуулан үйл ажиллагаагаа явуулж байна.

#### Дүгнэлт:

Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт "Цахим Монгол" төрийн шуурхай үйлчилгээ, "Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилт 5.3-д "Хүний хөгжлийг дэмжсэн, үр дүн, үр нөлөөтэй цахим засаглалыг төлөвшүүлнэ.", "Шинэ сэргэлтийн бодлого", "Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого 2025"-ийн 2.3.8-д "Төрийн байгууллагын үйл ажиллагааны бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх, засаглалыг ардчилсан, нээлттэй, хүнд сурталгүй, ил тод, хариуцлагатай байдлыг идэвхжүүлэх, төрийн үйл ажиллагааны инновацыг дэмжиж, цахим засгийн хөгжлийг боловсронгуй болгох замаар цахим засаглалыг хөгжүүлнэ" гэж тус тус заасныг үндэслэн 2022 онд Баянхонгор аймаг цахим засаглал, цахим шилжилтэд төр-хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан "ДИЖИТАЛ БАЯНХОНГОР" болох томоохон зорилтыг дэвшүүлж ажилласан.

Төрийн цахим үйлчилгээг иргэд, олон нийтэд танилцуулах, "E-Mongolia.mn" болон бусад цахим системээр дамжуулан өөрт хэрэгтэй үйлчилгээг хэрхэн, яаж авах талаар иргэдэд сурталчлах, тайлбарлан таниулах зорилгоор "Цахим жишиг аймаг" хөтөлбөрийн хүрээнд Улсын Их хурлын тамгын газар, Цахим хөгжил, харилцаа холбооны яам, E-Mongolia академи, Баянхонгор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг Даргын Тамгын газар хамтран 2022.05.22 "Дижитал Баянхонгор" нээлттэй өдөрлөгийг зохион байгуулсан.

*e-mongolia.mn системд нэвтрүүлсэн орон нутгийн цахим үйлчилгээний жагсаалт*

№	Цахим үйлчилгээний нэр	Үйлчилгээ үзүүлэгч байгууллага
1	Авто тээврийн хэрэгслийн гэрчилгээ нөхөн олгох хүсэлт хүлээн авах	Баянхонгор аймгийн Авто Тээврийн төв
2	Авто тээврийн хэрэгслийг улсын бүртгэлээс хасуулах	
3	Авто тээврийн хэрэгслийн гэрчилгээ солих	
4	Хяналтын камерийн тодорхойлолт гаргах	Баянхонгор аймаг дахь цагдаагийн газар
5	Цооног өрөмдөх, худаг гаргах зөвшөөрөл	Бөөнцагаан Орог нуурын сав газрын захиргаа
6	Ус ашиглуулах дүгнэлт гаргах ( Бөөнцагаан Орог нуурын сав газрын захиргаа)	
7	Элбэг ургамлыг судалгаа шинжилгээний зориулалтаар ашиглах зөвшөөрлийн хүсэлт хүлээн авах	Баянхонгор аймгийн Байгаль Орчин Аялал жуулчлалын газар

8	Хурын ус хуримтлуулж, хөв цөөрөм байгуулах, суваг шуудуу татах дүгнэлт гаргах	
9	Усны мэргэжлийн байгууллагын эрх олгох талаар дүгнэлт, Засаг даргын тодорхойлолт гаргах	
10	Цооног өрөмдөх, худаг гаргах зөвшөөрлийн хүсэлт	
11	Ус ашиглуулах дүгнэлт гаргуулах хүсэлт хүлээн авах (Байгаль орчин аялал жуулчлалын газар)	
12	Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ	
13	Ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт гаргах	Баянхонгор аймаг Онцгой байдлын газар
14	Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн гамшиг осол гарсан тухай акт, дүгнэлт	
15	(Баянхонгор аймаг) Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилэх тусгай зөвшөөрлийн үйлчилгээ	Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газар
16	Хөдөлмөр эрхлэлтийн лавлагаа	
17	Бусад лавлагаа	
18	Уншлагын танхимаар Эрдэм шинжилгээ судалгааны зорилгоор баримт судлах захиалга өгөх, цаг авах	Баянхонгор аймгийн төрийн архив
19	Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, хуулийн этгээдийн албан хэвлэмэл хуудасны захиалга өгөх	
20	Шинэ баригдах барилгад цэвэр, бохир усны техникийн нөхцөл олгох	
21	Хуучин баригдах барилгад цэвэр, бохир усны техникийн нөхцөл олгох	Чандмань-Баянхонгор ХК
22	Дулааны техникийн нөхцөл олгох	
23	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын архивын лавлагаа авах үйлчилгээ	<a href="https://egazar.gov.mn/">https://egazar.gov.mn/</a>
24	Барилга, байгууламжийг хот байгуулалтын мэдээллийн санд хаяг дугаар олгох	
25	Барилгын үйл ажиллагааг эхлүүлэх зөвшөөрөл олгох, ашиглалтанд оруулах холбоотой үйлчилгээнүүд	<a href="https://www.urban.gov.mn/">https://www.urban.gov.mn/</a>
26	Барилга байгууламжийн бүртгэлийн мэдээлэл, лавлагаа авах	
27	Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл сунгах	Баянхонгор Эрүүл мэндийн газар
28	Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нэмэлт өөрчлөлт оруулах	
29	Тамхи худалдан борлуулах тусгай зөвшөөрөл шинээр авах, сунгах /Баянхонгор сум/	Баянхонгор сум ЗДТГ
30	Ломбардын үйл ажиллагаа сунгах, шинээр авах тусгай зөвшөөрөл	
31	Жижиг дунд үйлдвэрлэл дэмжих орон нутгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан эсэх тодорхойлолт	Баянхонгор аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газар

• Төрийн үйлчилгээний нэгдсэн төв нь 2019 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн операторын хэлбэрээр үйлчилгээ үзүүлдэг “Үйлчилгээний нэгдсэн төв” болж

өөрчлөн зохион байгуулагдаж, 5 төрийн байгууллагын 198 төрлийн үйлчилгээг иргэдэд хүргэн ажиллаж байна.

- "Иргэдийн санал гомдол илгээх систем"-ийг ашиглалтад оруулснаар төрийн байгууллагын үйл ажиллагаанд иргэдийн сэтгэл ханамжийн судалгаа авах, иргэдээс өргөдөл, санал гомдол хүлээж авах, шийдвэрлэх явцыг тухайн мэдээлэл оруулсан иргэний гар утсанд шууд мэдээлэх зэргээр иргэд төрийн байгууллагын үйл ажиллагаанд шууд хяналт тавих боломжтой болсон.

- Монгол Улсын Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах төвийн орон нутагт иргэдийг сонсох, иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, иргэдийн санал, санаачилгын эргэх холбоог сайжруулах, уг тогтолцоог бий болгох, төрийн үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй, хүнд сурталгүй хүргэхээр санал гомдлыг шийдвэрлэх ажилтан аймгийн Засаг даргын тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Үйлчилгээний нэгдсэн төвийн менежер хариуцан ажилладаг

И-Монгол академиас хөгжүүлэлт хийгдэж буй [ep.e-mongolia.mn](http://ep.e-mongolia.mn) системд төсвийн болон орон нутгийн өмчит бүх байгууллагыг бүрэн шилжүүлсэн байна.

**Санал (зөвлөмж):**

1. E-mongolia системд нэвтрүүлсэн орон нутгийн олон шатлалт үйлчилгээг илүү хялбар болгох, үйлчилгээний тоог нэмэгдүүдэх, иргэдэд үйлчилгээг илүү ойртуулах
2. Цахим аймаг арга хэмжээний төлөвлөгөөг Ухаалаг Баянхонгор хөтөлбөртэй уялдуулан боловсруулж аймгийн хэмжээний цахим засаглалыг хөгжүүлэх бодлогын баримт бичиг боловсруулж, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлах;
3. Байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем ашиглалтыг аймгийн хэмжээнд 100 хувьд хүргэх;
4. Албан бичиг төлөвлөлтийг бүрэн цахимжуулж, сумдаас гарч байгаа тушаал, захирамжид холбогдох бодлогын хэлтэс хяналт хийх боломжийг бүрдүүлэх;

**Дөрөв. Монгол Улсын Засгийн газраас “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого”, “Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 419 дүгээр тогтоол, Засгийн газрын хуралдааны 56 дугаар тэмдэглэл, Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 157-р захирамжаар байгуулсан ажлын багийн 2022-2024 онд хэрэгжүүлэх ажлын ерөнхий төлөвлөгөөний хүрээнд:**

Монгол Улсын Засгийн газраас Хот Хөдөөгийн сэргэлтийн бодлогыг эрчимжүүлэх ажлын хүрээнд Аймгийн Засаг даргын 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн А/661 захирамжаар Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргаар ахлуулсан 9 хүний бүрэлдэхүүнтэй дэд ажлын хэсэг байгуулсан.

Тус ажлын хэсгээр “Нээлттэй Баянхонгор аймаг” хөтөлбөр, дэд ажлын хэсгийн 2023-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан 2023 оны 01 дүгээр сарын 16-нд Эрчим хүчний дэд сайд, ЭЗХЯамны Бүс аж үйлдвэрийн газрын дарга, Удирдлагын академийн багш, аймгийн ИТХурлын дарга, төлөөлөгчид, аймаг сумд, байгууллагын удирдлагууд оролцсон нийт 140 хүний бүрэлдэхүүнтэй сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

Дэд ажлын хэсгийн 2023-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 5 зорилт, 25 арга хэмжээ, 12 тэрбум 498 сая төгрөгний санхүүжилттэйгээр төлөвлөн батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Жич: Дэлгэрэнгүй тайлангуудыг хавсралтаар хүргүүлэв.

ТАНИЛЦСАН:  
БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГА

Д.МӨНХСАЙХАН

ХЯНАСАН:  
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН  
ДАРГА

Л.МАНДАЛ

ТАЙЛАН БИЧСЭН:  
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН  
МЭРГЭЖИЛТЭН

Э.МӨНХТУЯА

